



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/308

Булган сум

**Аймгийн аюулгүйн нөөцийн  
тэжээлийг худалдан борлуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 327 дугаар тогтоол, аймгийн Шуурхай штабын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн аюулгүйн нөөцөд 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтад бэлтгэсэн тэжээлийг сумдад тараах хуваарийг хавсралтаар баталж, 1 тонн тэжээлийн үнийг 682,500 (зургаан зуун наян хоёр мянга таван зуу) төгрөгөөр худалдан борлуулахыг аймгийн “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Лхагваням)-д зөвшөөрсүгэй.

2.Худалдан борлуулсан өвс, тэжээлийн хөрөнгийг Мал хамгаалах сангийн 100040051410 дансанд төвлөрүүлэхийг аймгийн “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Лхагваням)-д үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны  
дүгээр сарын 2-ны/ний өдрийн  
А/308 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН АЮУЛГҮЙН НӨӨЦИЙН ТЭЖЭЭЛИЙГ  
СУМДАД ТАРААХ ХУВААРЬ

д/д	Сумын нэр	Тэжээл	
		Тоо хэмжээ (тн)	Үнэ (682,500 төг)
1	2	3	4
1	Бугат	2.5	1,706,250
2	Орхон	1	682,500
3	Могод	2.5	1,706,250
4	Хангал	2	1,365,000
5	Хишиг-Өндөр	2.5	1,706,250
6	“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй “ОНӨХХК	0.5	хорогдол
	<b>Дүн</b>	<b>11</b>	<b>7,166,250</b>

--o00o--